



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/БЗБ

Хэрлэн сум

Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын
гэрээ, үнэмлэхний загвар гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, 16.1.10, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 37.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт орших Түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилон ажиллуулах гэрээг нэгдүгээр хавсралтаар, үнэмлэхний загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилох ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёл, урлагийн газрын дарга (Т.Зулбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дугаар сарын 25-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ХАРУУЛТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

202_ оны _____ дүгээр сарын _____-ны
өдөр №..... сум

Энэхүү гэрээг нэг талаас Хэнтий аймгийн сумын ЗДТГ-ыг төлөөлөн..... багийн Засаг дарга овогтой, Нөгөө талаас Хэнтий аймгийн сумын багийн иргэн /..... байгаль хамгаалах нөхөрлөлийн ахлагч/..... овогтой /цаашид "Гэрээт харуул" гэнэ/ нар Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор "Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д, БСШУС-ын 2020 оны А/161 дугаар тушаалаар "Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй сумын багийн нутаг дэвсгэрт орших дурсгалт газрын бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангах, хадгалалт, хамгаалалтын орчин нөхцөлийг сайжруулах, талуудын хоорондын харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

Хоёр. Гэрээний хугацаа

- 1.1. Гэрээ байгуулагдаж, талууд тамга тэмдэг бүхий гарын үсэг зурагдсанаар ажил эхэлж, дуусах эцсийн хугацаа ... оны ... дугаар сарын ... -ны өдөр буюу 1 жилийн хугацаатай байна.
- 1.2. Гэрээт харуул нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон бол энэ тухайгаа нэн даруй нөгөө талд мэдэгдэнэ.

2.

1.3 Талуудын аль нэг нь гэрээ цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг дахин 1 жилийн хугацаагаар сунгагдсан тооцно.

Гурав. Сумын Засаг даргын хүлээх эрх, үүрэг

3.1. Түүх, соёлын дурсгалыг ажлын хэсэг гарган, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэлд тулгуурлан гэрээт харуулд хүлээлгэн өгнө.

3.3. Түүх, соёлын дурсгалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах болзошгүй нөлөөллөөс сэргийлэх зорилгоор гэрээт харуулд заавар, зөвлөмж өгөх, түүх, соёлын дурсгалыг хадгалж хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих, сэргээн засварлах, хуулийг хэрэгжүүлэх талаар явуулж буй идэвхтэй үйл ажиллагааг дэмжинэ.

3.4. Соёлын өвийн гэрээт харуулыг орон нутгийн боломжит нөхцөлийн дагуу урамшуулах

3.9. Соёлын өвийн гэрээт харуулд итгэмжлэх үнэмлэх олгох

3.10. Соёлын өвийн гэрээт харуулын ажлын үзүүлэлтийг дүгнэх

3.11. Соёлын өвийн хууль бус хайгуул, малтлага хийхийг хориглох, таслан зогсоох

3.12. Соёлын өвийн гэрээт харуулын аюулгүй байдалд онцгой анхаарал тавьж ажиллах

Дөрөв. Соёлын өвийн гэрээт харуулын эрх, үүрэг

4.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаарх мэдээлэл, хамгаалалтын хэрэгслээр хангагдах, урамшуулал авах

4.2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтлийг засварлах, авран хамгаалах талаар эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх

4.3. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг үзэж сонирхох, судлахаар ирсэн байгууллага иргэдийг бүртгэх, тэдний багаж хэрэгслийг шалгах, соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг тайлбарлаж таниулах

4.4. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын орчинд зөвшөөрөлгүйгээр металл хайгч, тусгай багаж ашиглуулахгүй байх

4.5. Хууль бус хайгуул, малтлага хийхийг хориглох, таслан зогсоох, үйл ажиллагааг нь баримтжуулах, мэдээлэх

4.6. Хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн этгээдийг улсын байцаагч болон холбогдох хуулийн байгууллагад мэдээлэх

4.7. Хамгаалж байгаа соёлын өвийн ойролцоо байнга оршин суух

3.

4.8. Сумын ИТХ, Засаг дарга, хэсгийн төлөөлөгч, Байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, Соёлын төвийн Бүртгэл мэдээлэл хариуцсан ажилтнуудтай нягт уялдаа холбоотой ажиллах

4.9. Дурсгалт газрын хамгаалалтын талаар тайлагнах /баримтжуулах/

Тав. Бусад

5.1. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж 1 хувийг сумын ЗДТГ, 1 хувийг сумын Соёлын төвд, 1 хувийг гэрээт харуулд тус тус хадгалуулна.

5.2. Гэрээг нэг удаад 12 сарын хугацаагаар байгуулж жил бүр гэрээг шинэчилж байгуулна.

5.3. Энэхүү гэрээний 3.4-д заасан урамшуулал олгох хэлбэрийг Сумын Засаг даргын тамгын газрын дотоод журамд тусгаж хуулийн хэрэгжилтыг хангаж ажиллана

5.4. Гэрээгээр хамгаалуулах дурсгалт газрын жагсаалт бүртгэл, ач холбогдлын талаар мэргэжлийн байгууллага Соёл, урлагийн газар, Музей, Соёлын төвөөс мэдээлэл авч болно.

5.5. Гэрээт харуул томилох ажилд багийн Засаг дарга, ИНХ идэвхи санаачлага гарган оролцох

Гэрээг байгуулсан:

Сумын Засаг дарга:...../ /

Утас:

Хаяг:.....

Багийн Засаг дарга:...../ /

Утас:

Хаяг:.....


Багийн иргэн гэрээт харуул:/ /

Утас:

Хаяг:..... РД:.....

Аймгийн Засаг даргын 2022
оны 10 дугаар сарын 25-ны
А/536 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ГЭРЭЭТ ХАРУУЛЫН
ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР



ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ
ДУРСГАЛЫН ГЭРЭЭТ ХАРУУЛ

ҮНЭМЛЭХ

№:

ХҮНДЭТ.....ТАНЫГ

ХЭНТИЙ АЙМГИЙН СУМЫН НУТАГ
ДЭВСГЭРТ ОРШИХ УЛС, АЙМАГ НИЙСЭЭЛИЙН
ХАМГААЛААЛТАД БАЙХ ТҮҮХ СОЁЛЫН ҮЛ
ХӨДЛӨХ ДУРСГАЛЫГ ГЭРЭЭГЭЭР ХАРИУЦСАН
ХАМГААЛААГЧ ТУЛ ҮНЭМЛЭХ ОЛГОВ.

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ

2022 он